“ФИСКАЛ АУДИТ” ХХК

FISCAL

AUDITING, ADVISORY, ASSURANCE

# АУДИТЫН ТАЙЛАН

“ГРЭЙТ ЛОРД ББСБ” ХХК-ИЙН
2025 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2026 он

FISCAL

AUDITING, ADVISORY, ASSURANCE

# АГУУЛГА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ............................3-4

2025 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН.......................................................5-9

Аудитлагдсан баланс.......................................................5-6

Аудитлагдсан орлогын тайлан..........................................7

Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан.....................8

Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан........................9

Санхүүгийн тайлангийн тодруулга............................10-16

Удирдлагын захидал....................................................17-22

AUDITING, ADVISORY, ASSURANCE
**"ФИСКАЛ АУДИТ" ХХК**
Монгол Улс,Улаанбаатар хот-14250
Сүхбаатар дүүрэг 4-р хороо,Сөүлийн
гудамж 23 Түшиг төв 505 тоот
Утас/факс:(976)-70106099,99117709
E-mail:audit@fiscal.mn,altantugs@fiscal.mn
_____________ № ____________

**" ГРЭЙТ ЛОРД ББСБ "ХХК - ИЙН УДИРДЛАГАД**

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

**" ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК**-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд **"ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК**-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

## Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

## Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайлангийн талаархи компаний удирдлагын хариуцлага**

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материалаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

**Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилсан сонгодог бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компаний санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдалд байгаа эсэхийг тодорхойлсон.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын "Компаний тухай хууль"-ийн 5-р зүйлд заасан хуулийн этгээд болох **" ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК**-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

"ФИСКАЛ АУДИТ" ХХК
FISCAL AUDIT LLC
5384597 СБТ0076
УЛААНБААТАР ХОТ

ЗАХИРАЛ Д.АЛТАНТӨГС

FISCAL

AUDITING, ADVISORY, ASSURANCE

" ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК

2025 оны 12 сарын 31ний өдрөөрх

## Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан

(Төгрөг)

| ХӨРӨНГӨ | 2024/12/31 | 2025/12/31 |
|---|---|---|
| **Санхүүгийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 332,603,593.50 | 55,451,314.01 |
| Зээл | 2,270,271,057.50 | 2,725,314,070.56 |
| Факторингийн тооцооны авлага | - | - |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө | - | - |
| Хөрөнгө оруулалт | - | - |
| Бусад санхүүгийн хөрөнгө | | 24,884,775.48 |
| **Санхүүгийн хөрөнгийн дүн** | **2,602,874,651.00** | **2,805,650,160.05** |
| **Санхүүгийн бус хөрөнгө** | | |
| Татвар, НДШ-ийн авлага | - | 12,296,664.03 |
| Үндсэн хөрөнгө | 10,616,100.00 | 70,987,774.03 |
| Биет бус хөрөнгө | - | - |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | - |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | - | - |
| **Санхүүгийн бус хөрөнгийн дүн** | **10,616,100.00** | **83,284,438.06** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,613,490,751.00** | **2,888,934,598.11** |

**"ФИСКАЛ АУДИТ" ХХК**

Захирал: Д. Алтантөгс

Аудитор: Н. Болорцэцэг

Шинжээч: Г. Болор

FISCAL

AUDITING, ADVISORY, ASSURANCE

" ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК

2025 оны 12 сарын 31ний өдрөөрх

**Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан**

(Төгрөг)

| | 2024/12/31 | 2025/12/31 |
|---|---|---|
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | |
| **Өр төлбөр** | | |
| Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр | - | - |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | - | - |
| Бусад эх үүсвэр | - | - |
| Үүсмэл санхүүгийн өр төлбөр | - | - |
| Бусад санхүүгийн өр төлбөр | - | - |
| Хоёрдогч өглөг | - | - |
| Давуу эрхийн хувьцаа өр төлбөр | - | - |
| **Санхүүгийн өр төлбөрийн дүн** | - | - |
| Татвар,НДШ-ийн өр төлбөр | - | - |
| Нөөц /Болзошгүй өр төлбөр/ | - | 47,973,156.75 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | - | - |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | - | - |
| **Санхүүгийн бус өр төлбөрийн дүн** | - | **47,973,156.75** |
| **Өр төлбөрийн дүн** | - | **47,973,156.75** |
| **Эзэмшигчийн өмч** | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 2,500,000,000.00 | 2,500,000,000.00 |
| Өмчийн бусад хэсэг | - | - |
| Хуримтлагдсан ашиг / алдагдал / | 113,490,751.00 | 340,961,441.36 |
| **Эзэмшигчийн өмчийн нийт дүн** | **2,613,490,751.00** | **2,840,961,441.36** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **2,613,490,751.00** | **2,888,934,598.11** |

"ФИСКАЛ АУДИТ" ХХК

"ФИСКАЛ АУДИТ" ХХК FISCAL AUDIT LLC УЛААНБААТАР ХОТ

Захирал: Д. Алтантөгс

Аудитор: Н. Болорцэцэг

Шинжээч: Г. Болор

FISCAL
AUDITING, ADVISORY, ASSURANCE

**" ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК**

2025 оны 12 сарын 31ний өдрөөрх

**Аудитлагдсан дэлгэрэнгүй орлогын тайлан**

| | 2024/12/31 | 2025/12/31 |
|---|---|---|
| Хүүгийн орлого | 201,886,502.53 | 823,856,194.72 |
| Хүүгийн зардал | - | - |
| **Цэвэр хүүгийн орлого** | **201,886,502.53** | **823,856,194.72** |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | - | - |
| Хүүгийн бус зардал | - | - |
| **Цэвэр хүүгийн бус орлого/зардал** | - | - |
| **Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал** | | |
| Болзошгүй эрсдлийн зардал | | 72,347,811.77 |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал** | - | **(72,347,811.77)** |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 18,351,600.00 | 21,564,666.45 |
| Үндсэн үйл ажиллагааны зардал | 94,137,268.09 | 363,670,397.60 |
| **Ердийн үйл ажиллагааны ашиг/ алдагдал** | **126,100,834.44** | **409,402,651.80** |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **126,100,834.44** | **409,402,651.80** |
| Орлогын татварын зардал | 12,610,083.44 | 41,025,885.20 |
| **Цэвэр ашиг** | **113,490,751.00** | **368,376,766.60** |

"ФИСКАЛ АУДИТ" ХХК FISCAL AUDIT LLC УЛААНБААТАР ХОТ

**"ФИСКАЛ АУДИТ" ХХК**

Захирал: [signature] Д.Алтантөгс

Аудитор: Н. Болорцэцэг [signature] Н. Болорцэцэг

Шинжээч: [signature] Г. Болор

DITING, ADVISORY, ASSURANCE

" ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК

2025 оны 12 сарын 31ний өдрөөрх

**Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан**
(Төгрөг)

| Агуулга | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Дахин үнэлгээний нэмэгдэл | Халаасны хувьцаа | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг/алдагдал | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| **оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **2,499,980,000.00** | - | - | - | - | - | **2,499,980,000.00** |
| ан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны үлга | | - | - | - | - | - | - |
| **үулсан үлдэгдэл** | | - | - | - | - | | |
| он хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - | - | - |
| нгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - | - | - |
| д гарсан өөрчлөлт | 20,000.00 | - | - | - | - | - | - |
| ын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз | - | - | - | - | - | - | - |
| нт үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | - | 113,490,751.00 | **113,490,751.00** |
| рилсан ногдол ашиг | - | - | - | - | | | - |
| цаат капиталын өсөлт | | - | - | - | - | - | - |
| **оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **2,500,000,000.00** | - | - | - | - | **113,490,751.00** | **2,613,490,751.00** |
| **оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **2,500,000,000.00** | - | - | - | - | **113,490,751.00** | **2,613,490,751.00** |
| ан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны үлга | | - | - | - | - | 85,425,563.24 | **85,425,563.24** |
| **үулсан үлдэгдэл** | **2,500,000,000.00** | - | - | - | - | **198,916,314.24** | **2,698,916,314.24** |
| он хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - | - | - |
| нгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - | - | - |
| д гарсан өөрчлөлт | - | - | - | - | - | - | - |
| ын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз | - | - | - | - | - | - | - |
| нт үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | - | 368,376,766.58 | **368,376,766.58** |
| рилсан ногдол ашиг | - | - | - | - | - | -226,331,639.46 | **(226,331,639.46)** |
| цаат капиталын өсөлт | - | - | - | - | - | - | - |
| **оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **2,500,000,000.00** | - | - | - | - | **340,961,441.36** | **2,840,961,441.36** |

-

**"ФИСКАЛ АУДИТ" ХХК**

Захирал: Д. Алтантөгс

Аудитор: Н. Болорцэцэг

Шинжээч: Г. Болор

FISCAL

AUDITING, ADVISORY, ASSURANCE

" ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК
2025 оны 12 сарын 31ний өдрөөрх
**Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан**

(Төгрөг)

| | 2024/12/31 | 2025/12/31 |
|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -2,156,780,306.50 | -26,469,790.87 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (10,616,100.00) | (78,043,900.00) |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | (172,638,588.62) |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | **(2,167,396,406.50)** | **(277,152,279.49)** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | **2,500,000,000.00** | **332,603,593.50** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **332,603,593.50** | **55,451,314.01** |

**"ФИСКАЛ АУДИТ" ХХК**

Захирал: Д.Алтантөгс

Аудитор: Н. Болорцэцэг

Шинжээч: Г. Болор

" ГРЭЙТ ЛОРД ББСБ" ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2025 оны 12-р сарын 31.

# 1. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ

" ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь МУ-ын СЭЗЯамнаас гаргасан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, дансны үлгэрчилсэн заавар" санхүүгийн тайланг бэлтгэх аргачлалын дагуу аккурэл сууриар бэлтгэгдсэн. Энэхүү тайлагналын суурь нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандарттай нийцэж байна.

# 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

## а. Тайлагнасан валют

Компаний данс бүртгэл нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хөтлөгддөг ба санхүүгийн тайланг төгрөгөөр бэлтгэсэн болно.

## б. Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хэрэглүүд

Мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, арилжааны банк дахь харилцах дансдаас бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах гурван сар ба түүнээс бага хугацаанд хөрвөх богино хугацаат хөрөнгө оруулалт, түргэн борлогдох үнэт цаас байхгүй.

## в. Авлага

Авлага нь үүссэн тухайн үеийн нэхэмжлэгдэх дүнгээр бүртгэгдсэн. Авлагын хувьд насжилт гаргаж, цуглуулагдах магадлалыг үнэлж тооцдоггүй. Өөрөөр хэлбэл цэвэр боломжит үнэ цэнийг тооцдоггүй.

## г. Бараа материал

Бараа материалыг өртгөөр нь бүртгэдэг. Бараа материалын бүрэлдэхүүнд борлуулах бараа бүтээгдэхүүн, хангамж үйлчилгээний зориулалтын ашиглах материал үнэт зүйлс багтдаг.

## д. Урьдчилж гарсан зардал

Мөнгөөр төлөгдсөн бөгөөд дараагийн тайлант үед хамаарах зардлыг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэдэг. Урьдчилж гарсан зардлыг хамрах тайлант үеийн холбогдох зардлын дансанд хаадаг.

**е. Үндсэн хөрөнгө ба элэгдэл**

Үндсэн хөрөнгө нь санхүүгийн тайланд анхны өртөг болон шинээр нэмж оруулсан хөрөнгө оруулалтыг капиталжуулан нэмэгдүүлсэн дүнгээс хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр илэрхийлсэн.

Хөрөнгийг данснаас хасах үед анхны болон шинэчлэн тогтоосон өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хасаж, үлдэх өртөг ба борлуулсан үнийн зөрүүгээр данснаас хассаны ашиг алдагдлыг тооцдог.

Элэгдлийг хөрөнгийн ашиглагдах жилийг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулдаг. Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа нь Монгол улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуультай нийцдэг. Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа нь дараах хэмжээтэй байна.

| Үндсэн хөрөнгийн төрөл | Ашиглах жил |
|---|---|
| Барилга байгууламж | 25 |
| Тоног төхөөрөмж | 10 |
| Тээврийн хэрэгсэл | 10 |
| Тавилга эд хогшил | 10 |
| Компьютер дагалдах хэрэгсэл | 2 |

**з. Богино хугацаат өр төлбөр**

Богино хугацаат өр төлбөрийг тухайн үед үүссэн нэхэмжлэгдэх буюу нэрлэсэн дүнгээр бүртгэлд тусгадаг. Өглөгийн хувьд хөнгөлөлт, хасагдуулга нөөц тооцдоггүй.

**ж. Өмч**

Компанийн өөрийн хөрөнгө ( Дүрмийн сан) нь энгийн хувьцаа, халаасны хувьцаа, нэмж төлөгдсөн капитал, хөрөнгийн дахин үнэлгээний нөөц зэргээс бүрддэг бөгөөд давуу эрхтэй хувьцаа зэрэг бусад данс байхгүй.

**и. Орлогыг хүлээн зөвшөөрөлт**

Бараа үйлчилгээг үзүүлж, өмчлөх эрх нь шилжсэн үед борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг. Ногдол ашгийн орлогыг шилжиж ирсэн үед нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

**к. Зарлагын хүлээн зөвшөөрөлт**

Зардлыг орлогын хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан нэг цаг хугацаанд тооцож байна. Зардлыг аккруэл сууриар бүртгэдэг.

**л. Гадаад вальютын ажил гүйлгээ, хөрвүүлэлт**

Гадаад вальютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэдэг. Гадаад вальютаарх мөнгөн зүйлсийг балансын дуусвар болсон өдрийн албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэсэн.

**м. Татвар**

*Орлогын татвар*

Татварын хуулийн дагуу 6.0 тэрбум төгрөг хүртэлх татвар ноогдох жилийн орлогод 10 хувиар, 6.0 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол 600.0 сая төгрөг дээр 6.0 тэрбумаас дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж, орлогын албан татвар ногдуулж төлдөг.

*Нэмэгдсэн өртгийн албан татвар*

Компани нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бөгөөд борлуулалтад 10 хувиар тооцож, нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөг.Нэмэгдсэн өртгийн албан татвартай худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн татварыг борлуулалтаас тооцсон татварын өглөгөөс суутган тооцдог.

*Хувь хүний орлогын албан татвар*

Монгол улсын "Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулийн дагуу компани ажиллагсад болон гэрээт ажилчидад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогоос 10 хувиар татвар суутгаж төсөвт төлөх үүрэгтэй.

**л. Нийгмийн даатгалын шимтгэл**

Монгол улсын Нийгмийн болон Эрүүл мэндийн даатгалын туай хуулийн дагуу ажиллагсдын сарын нийт цалингаасс 11,5 хувиар тооцож ажиллагсад, 12,5 хувиар тооцож ажил олгогч нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөг. Энэ нь Засгийн газрын нийгмийн даатгалын төлөвлөгөө бөгөөд компани ажиллагсаддаа зориулсан тусгай нийгмийн даатгалын төлөвлөгөө, сангүй болно.

## 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

| | Ангилал | 2024.12.31 | | 2025.12.31 | |
|---|---|---|---|---|---|
| | | Валют | Төгрөг | Валют | Төгрөг |
| | **а. Касс дахь бэлэн мөнгө** | | | | |
| 1. | Касс дахь бэлэн мөнгө | | 330 315 476.62 | | 42 429 587.51 |
| | **Дэд дүн** | | **330 315 476.62** | | **42 429 587.51** |
| | **б.Харилцах дахь бэлэн мөнгө** | | | | |
| 2. | Харилцах Голомт банк төгрөг | | | | |
| 3. | Харилцах Хаан банк төгрөг | | 2 288 116.88 | | 13 021 726.50 |
| | **Дэд дүн** | | | | |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн** | | | **332 603 593.50** | | **55 451 314.01** |

## 3. ЗЭЭЛ

| | Зээл | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Хэвийн зээл | 2 240 271 057.50 | 2 702 287 583.58 |
| 2. | Анхаарал хандуулах | 30 000 000.00 | 13 475 038.60 |
| 3. | Чанаргүй зээл | | |
| 4. | Хэвийн бус | | |
| 5. | Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | | 10 225 200.31 |
| 6. | Муу | | 71 674 059.84 |
| 7. | Зээлийн эрсдлийн сан | | -72 347 811.77 |
| | **Нийт зээл** | **2 270 271 057.50** | **2 725 314 070.56** |

## 4. САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ТООЦООНЫ АВЛАГА/ЦЭВРЭЭР/

| | Зээл төрлөөрөө | 2024.06.31 | | 2024.12.31 | |
|---|---|---|---|---|---|
| | | валют | төгрөг | валют | төгрөг |
| 1. | Нийт санхүүгийн түрээсийн авлага | - | | | |
| 2. | Хэвийн санхүүгийн түрээсийн авлага | - | | | |
| | **Нийт авлага /цэврээр/** | - | | | |

## 5. ХУРИМТЛУУЛЖ ТООЦСОН ХҮҮГИЙН АВЛАГА

| | Төрөл | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага | | |
| | **Нийт дүн** | | |

## 6. УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРҮҮД

| | Урьдчилгаа төлбөрийн төрөл | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Түрээсийн барьцаа | | |
| 2. | Интернэтийн барьцаа | | |
| 3. | Ажлын хөлсний урьдчилгаа | | |
| 4. | Урьдчилж төлсөн зардал тооцоо | | |
| 5. | УТХураамж дүн | | |
| | **Нийт авлагын дүн:** | | |

## 7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгө нь газар, барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, боо хөгжим тоног төхөөрөмж зэргээс бүрддэг. Үндсэн хөрөнгийг дараах гол ангиллаар харуулав.

А. Өртөг

| Утга | Газар | Барилга байгууламж | Тоног төхөөрөмж | Тээврийн хэрэгсэл | Тавилга, эд хогшил | Комьютер, бусад хэрэгсэл | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| **024.06.31** | - | - | - | - | - | **10 616 100.00** | **10 616 100.00** |
| **эмэгдсэн** | | - | - | - | 55 480 000.00 | 15 099 300.00 | **70 579 300.00** |
| **асагдсан** | | - | - | - | - | - | - |
| **025.12.31** | - | - | - | - | **55 480 000.00** | **25 715 400.00** | **81 195 400.00** |

Б. Хуримтлагдсан элэгдэл

| Утга | Газар | Барилга байгууламж | Тоног төхөөрөмж | Тээврийн хэрэгсэл | Тавилга, эд хогшил | Комьютер, бусад хэрэгсэл | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| **024.06.31** | | - | - | | | | |
| **эмэгдсэн** | | 7 717 312.21 | - | | 2 490 313.76 | | **10 207 625.97** |
| **асагдсан** | | - | - | | | | |
| **24.12.31** | - | **7 717 312.21** | - | - | **2 490 313.76** | - | **10 207 625.97** |

## 8. БОГИНО ХУГАЦААТ ӨГЛӨГ

| | Өглөгийн төрөл | 2024.12.31 | | 2025.12.31 | |
|---|---|---|---|---|---|
| | | валют | төгрөг | валют | төгрөг |
| 1 | Татварын өглөг | - | - | - | |
| | -Төлөгдөх хугацаандаа байгаа | - | - | - | 47 973 156.75 |
| 2. | -Хугацаа хэтэрсэн | - | - | - | - |
| 3. | Өрийн бичгийн өглөг | - | - | - | - |
| 4. | Санхүүгийн дериватившийн өглөг | - | - | - | - |
| 5. | Төслийн зээлийн богино хугацаат санхүүжилт | - | - | - | - |
| 6. | Бусад өглөг | - | | | |
| | Нийт дүн | - | 0 | 0 | 0 |

## 9. ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

| № | Хувьцаа эзэмшигч | Эхний үлдэгдэл | Нэмэгдсэн/ хасагдсан | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| | | Дүн | Дүн | Дүн |
| 1. | Эзний өмч/хувийн/ | 2 500 000 000.00 | 0.00 | 2 500 000 000.00 |
| 2. | Хуримтлагдсан ашиг алдагдал | 113 490 751.00 | 227 470 690.36 | 340 961 441.36 |
| | Нийт | 2 613 490 751.00 | 227 470 690.36 | 2 840 961 441.36 |

## 10. ХҮҮГИЙН БУС ОРЛОГО

| | Орлогын төрөл | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Зээлийн хүүгийн орлого | | |
| 2. | Үйлчилгээний шимтгэл хураамжийн орлого | 18 351 600.00 | 21 564 666.45 |
| 3. | Харилцах дансны хүүгийн орлого | | |
| 4. | Хүүгийн бус орлого | | |
| 5. | Гадаад валютын арилжааны орлого | | |
| 6. | Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого | | |
| 7. | Бусад орлого | | |
| | Дүн | 18 351 600.00 | 21 564 666.45 |

## 11. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

| | Орлогын төрөл | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Цалин хөлс, шагнал | 28 500 000.00 | 100 619 135.91 |
| 2. | Нийгмийн даатгалын шимтгэл | 3 562 500.00 | 12 577 391.99 |
| 3. | Албан татвар,төлбөр,хураамжийн зардал | | |
| 4. | Албан томилолтын зардал | | |
| 5. | Ашиглалтын зардал | | 3 007 915.00 |
| 6. | Түрээсийн зардал | 16 349 666.00 | 42 960 000.00 |
| 7. | Сургалтын зардал | | |
| 8. | Аудитын төлбөр | | |
| 9. | Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал | | |
| 10. | Мэргэжлийн байгууллагын гишүүнчлэлийн төлбөр | | |
| 11. | Шуудан холбооны зардал | 1 543 178.56 | 6 676 397.15 |
| 12. | Зочин төлөөлөгчийн зардал | | |
| 13. | Элэгдэл хорогдлын зардал | | 10 207 625.97 |
| 14. | Шатахуун болон тээврийн зардал | 1 413 669.82 | 3 937 923.52 |
| 15. | Банкны үйлчилгээний зардал | 10 900.00 | |
| 16. | Зар сурталчилгааний зардал | | |
| 17. | Ариун цэврийн зардал | | |
| 18. | Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ | | |
| 19. | Бичиг хэргийн зардал | | |
| 20. | Хөдөлмөр хамгаалалт, галын аюулаас хамгаалах зардал | | |
| 21. | Захиалгат хэвлэлийн зардал | | |
| 22. | Үйл ажиллагааны бусад зардал | 42 757 353.71 | 182 795 308.10 |
| 23. | Даатгалын зардал | | |
| 24. | Бусад зардал | | |
| | **Үйл ажиллагааны зарлын дүн** | **94 137 268.09** | **362 781 697.64** |

## 12. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО БА ЗАРДАЛ

| | Ангилал | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Бусад ашиг (алдагдал) | | - |
| 2. | Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжсэн ашиг (алдагдал) | | - |
| 3. | Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжээгүй ашиг (алдагдал) | | - |
| 4. | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | - |
| 5. | Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз) | | - |
| | **Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал) –ын дүн** | **0** | **0** |

**“ГРЭЙТ ЛОРД ББСБ” ХХК-ИЙН**
**УДИРДЛАГАД**

AUDITING, ADVISORY, ASSURANCE

**“ФИСКАЛ АУДИТ” ХХК**
Монгол Улс,Улаанбаатар хот-14250
Сүхбаатар дүүрэг 4-р хороо,Сөүлийн
гудамж 23 Түшиг төв 505 тоот
Утас/факс:(976)-70106099,99117709,
E-mail:audit@fiscal.mn,altantugs@fiscal.mn
______________ № ____________

## УДИРДЛАГЫН ЗАХИДАЛ

Бид “ГРЭЙТ ЛОРД ББСБ” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитаар танай байгууллагын нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийн талаар бидний гүйцэтгэсэн аудитын горимууд нь хяналтын бүх процедур ба аргачлалыг тодорхойлох, дэлгэрэнгүй буюу нарийвчилсан зааварчилгаа өгөх бус бүртгэл ба дотоод хяналтын орчны талаар ойлголт авах зорилгоор хязгаарлагдсан билээ.

Аудитын тухай гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу ажлын явцад аудиторуудын анхааралд өртсөн зүйлүүдийг энэ баримт бичгээр толилуулж байна.

Зөвхөн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлд зориулан бэлтгэснээс өөр зорилго агуулаагүй бөгөөд бидний бэлтгэсэн дараах мэргэжлийн санал, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана гэдэгт та бүхэнд итгэж байна. Санал болгосон зөвлөмжүүдийн талаар хамтран ярилцах, хүлээн зөвшөөрсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажилд туслалцаа үзүүлэхэд бид бэлэн байх болно.

“ФИСКАЛ АУДИТ” ХХК
FISCAL AUDIT
УЛААНБААТАР ХОТ

ЗАХИРАЛ Д.АЛТАНТӨГС

**Асуудал-1 Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийн талаар:**

***Бодит байдал***

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн жилийн эцсийн үлдэгдэл нь E-balance дээрх үлдэгдэл нь аудитаар баталгаажсан дүнтэй таарч байсан. Гэтэл 2025 оны санхүүгийн тайлангийн аудит хийх явцад тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программ дээрх дүнгүүд зөрүүтэй байна. Үүнд:

| № | Дансууд | 2024.12.31-ний үлдэгдэл /Баталгаажсан дүн/ | 2025.01.01-ний үлдэгдэл/НББ-ийн программаар/ | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 332 603 593.50 | 362 380 536.88 | (29,776,943.38) |
| 2 | Зээл | 2 270 271 057.50 | 2 329 439 785.70 | (59,168,728.20) |
| 3 | Үндсэн хөрөнгө | 10 616 100.00 | 10 151 500.00 | 464,600.00 |
| 4 | Хуримтлагдсан ашиг | 113 490 751.00 | 198 916 314.24 | (85,425,563.24) |
| 5 | Хүүгийн орлого | 201 886 502.53 | 271 127 434.36 | (69,240,931.83) |
| 6 | Хүүгийн бус орлого | 18 351 600.00 | 23 186 600.00 | (4,835,000.00) |
| 7 | Орлогын албан татварын зардал | 12 610 083.44 | 1 261 008.34 | 11,349,075.10 |

Энэ талаар хэрхэн өөрчлөгдсөн тухай нягтлан бодогчоос асуухад: “Өмнөх асуудлыг мэдэхгүй байна. 2025 оны 9 сард ажлаа авахад НББ-ийн программийн үлдэгдэл ийм байсан” гэсэн хариултыг өгсөн.

Компаний удирдлагаас лавлахад 2026.03.03-ны №12 албан тоот ирүүлсэн байна. Үүнд: нийт орлоготой холбоотой үүссэн зөрүү 74 075 931.00 төгрөгийг Эврэст НББ-ийн программтай холбоотой гэсэн тайлбар ирүүлжээ. /Тоотыг хавсаргав/

***Нөлөөлөл***

Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл дүн зөрүүтэй тул санхүүгийн тайлан буруу бэлтгэгдсэн .

***Зөвлөмж***

1. Монгол Улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийг мөрдөж ажиллана уу. Хэрвээ аудитаар орсны дараа санхүүгийн тайлангаа засварлах нөхцөл байдал үүсвэл дахин аудитын байгууллагатай холбогдон мэргэжлийн зөвлөгөө авч эргэх холбоотой ажиллаж , засварлуулах боломжтойг гэдгийг ойлгоно уу.

2. Аудитын компани 2025 оны эхний үлдэгдлийг засаж холбогдох тохируулах бичилтийг хүргүүлсэн. /Хавсралт-1/

3. 2024 оны орлогын дүн НББ-ийн программаар 294 314 034.00 төгрөг гэж бүртгэгдсэн, E-tax сайтаар 220 238 103.00 төг буюу зөрүү 74 075 931.00 төгрөг байна. 2024 оны /E-tax/ татварын тайланг засварлах хугацаа дууссан ч гэсэн Холбогдох татварын байгууллагатай холбогдон зөвлөлгөө авна уу.

**Асуудал-2 Бэлэн мөнгөний дансны талаар:**

***Бодит байдал***

Тус байгууллагын "Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө" дансанд 2025.12.31-ний үлдэгдэл **55 451 314.01 төгрөг** байгаа ба үүнээс **Дотоодын банкинд байршуулсан мөнгө 13 021 726.50 төгрөг**, бэлэн **мөнгө дансанд 42 429 587.51 төгрөг** байна.

Кассын тайлангаа гүйлгээ гарсан тухайн тайлант сард бэлтгэдэггүй байна..2025 оны жилийн эцэст бэлэн мөнгөний тооллого хийж баталгаажуулаагүй байна. Энэ талаар нягтлан бодогч Мядагмаагаас асуухад: *"Гүйцэтгэх захирлын хувийн дансанд байгаа"* гэсэн тайлбарыг өгсөн болно.

***Нөлөөлөл***

Бэлэн мөнгө дансанд буй мөнгөн хөрөнгийн хэмжээ материаллаг бус дүнтэй бага хэдий ч санхүүгийн байдлын тайланг буруу бэлтгэгдсэн гэж үзэх боломжтой ба ирээдүйд үүсэх эрсдэлтэйг анхаарна уу.

***Зөвлөмж***

1. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах шаардлагатай байна.
2. Сангийн сайдын 2018.05.08-ны өдрийн №100 тоот тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, хөтлөх аргачлал"-ыг мөрдөж ажиллах нь зүйтэй байна. *<u>4.2.Мөнгөн гүйлгээний журнал</u> : 1.Аж ахуйн нэгж, байгууллага нь мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээг бүртгэхэд мөнгөн гүйлгээний журналыг ашиглана.2.Мөнгөн гүйлгээний журналыг банкны харилцах дансны хуулга, кассын тайлан тэдгээрт хавсаргасан анхны баримтыг үндэслэж хөтөлнө.3.Мөнгөн гүйлгээний журналд касс болон банкинд байгаа төгрөг, гадаад валютын дансдыг харилцах дансны нэр, валютын төрлөөр ангилж хөтөлнө.4.Мөнгөн гүйлгээний журналд тусгасан дансны бичилтийг Борлуулалт болон Худалдан авалтын журналд дахин бүртгэхгүй.5.Тусгай (жижиг) мөнгөн сан болон мөнгөтэй адилтгах зүйлсийг бүртгэхэд мөнгөн гүйлгээний журналыг ашиглана.*
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг:
   20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;
   20.2.6.***эд хөрөнгийн*** болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, ***үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;***" гэсэн заалтуудыг дагаж мөрдөж ажиллах ёстой.

**Асуудал-3 Ногдол ашгийн талаар:**

***Бодит байдал***

2025 оны Өмчийн өөрчлөлтийн тайлангийн " Хуваарилсан ногдол ашиг" хэсэгт 226 331 639.46 төгрөг тусгагдсан байна. Үүнд: Өмнөх оны ногдол ашиг 113 490 751.00 төгрөг, 2025 оны ногдол ашиг 112 840 888.46 төгрөгийн ногдол ашгаа тус тус авсан байна.

2025 оны Ногдол ашгаа урьдчилан авсан талаар хувьцаа эзэмшигч н.Саранцэцэг асуухад : Зайлшгүй компаниас мөнгө авах шаардлага үе үе гарч байна гэсэн.

***Нөлөөлөл***

Тайлант жилийн цэвэр ашиг нь Орлогын дэлгэрэнгүй тайлангаар 2025.12.31-ний өдрөөр эцэслэн бэлтгэгддэг гардаг тул Ногдол ашгийг урьдчилан авах нь санхүүгийн тайланд эрсдэл үүсгэх боломжтой.

***Зөвлөмж***

1. Тайлан жилийн санхүүгийн тайлан бүрэн бэлтгэгдэж дууссаны дараа , төрийн байгууллага болон аудитаар баталгаажсаны дараа Компаний тухай хуулинд заасны дагуу "Ногдол ашгаа" хуваарилж байхыг зөвлөж байна. Учир нь Санхүүгийн тайлангаар компани алдагдалтай ажилласан үед Ногдол ашиг хуваарилах боломжгүй байдаг.

2. Компаний удирдлагын хувийн хэрэгцээнд зайлшгүй хэрэглэгдэх мөнгө хөрөнгийн тооцоог "Хоорондын өр авлага" дансаар бүртгэгдэх нь зүйтэй. Тайлант оны эцэст Санхүүгийн тайлангууд бэлтгэгдсэний дараа Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр "Ногдол ашиг" хуваарилсаны дараа өр авлагын дансаас холбогдох тооцоог хийж байх хэрэгтэй.

"ФИСКАЛ АУДИТ" ХХК
FISCAL AUDIT LLC
5384517 ... 5T0676
УЛААНБААТАР ХОТ

**Зөвлөмжийг бэлтгэж хүргүүлсэн :**

Аудитын баг: Захирал, аудитор .................................................. Д.Алтантөгс /МНБ/

Аудитор .................................................................. Н.Болорцэцэг /МНБ/

Санхүүгийн шинжээч ............................................Г.Болор /МНБ/

FISCAL
AUDITING. ADVISORY. ASSURANCE

" ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК
2025 оны 12 сарын 31ний өдрөөрх
**Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан**

(Төгрөг)

| | 2024/12/31 | Тохируулах бичилт: Данены дебет /Дт/ | Тохируулах бичилт: Данены кредит /Кт/ | Тохируулены дараах эхний үлдэгдэл 2025/01/01 | 2025/12/31 |
|---|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | | |
| **Санхүүгийн хөрөнгө** | | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 332,603,593.50 | 29,776,943.38 | | 362,380,536.88 | 55,451,314.01 |
| Зээл | 2,270,271,037.50 | 55,488,728.20 | | 2,325,759,785.70 | 2,725,314,070.56 |
| *Факторингийн тооцооны авлага* | - | | | - | - |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө | - | | | - | - |
| Хөрөнгө оруулалт | - | | | - | - |
| Бусад санхүүгийн хөрөнгө | | 3,702,000.00 | | 3,702,000.00 | 24,884,775.48 |
| **Санхүүгийн хөрөнгийн дүн** | **2,602,874,651.00** | | | **2,691,842,322.58** | **2,805,650,160.05** |
| **Санхүүгийн бус хөрөнгө** | | | | | |
| Татвар, НДШ-ийн авлага | | | | - | 12,296,664.03 |
| *Үндсэн хөрөнгө* | 10,616,100.00 | | 464,600.00 | 10,151,500.00 | 70,987,774.03 |
| Биет бус хөрөнгө | - | | | - | - |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | | | - | - |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | - | | | - | - |
| **Санхүүгийн бус хөрөнгийн дүн** | **10,616,100.00** | | | **10,151,500.00** | **83,284,438.06** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,613,490,751.00** | | | **2,701,993,822.58** | **2,888,934,598.11** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | | | | |
| **Өр төлбөр** | | | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр | - | | | | - |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | - | | | | - |
| Бусад эх үүсвэр | - | | | | - |
| Үүсмэл санхүүгийн өр төлбөр | - | | | | - |
| Бусад санхүүгийн өр төлбөр | - | | | | - |
| Хоёрдогч өглөг | - | | | | - |
| Давуу эрхийн хувьцаа өр төлбөр | - | | | | - |
| **Санхүүгийн өр төлбөрийн дүн** | - | | | | - |
| Татвар,НДШ-ийн өр төлбөр | - | | | | - |
| Нөөц /Болзошгүй өр төлбөр/ | - | | 3,077,508.34 | 3,077,508.34 | 47,973,156.75 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | - | | | | - |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | - | | | | - |
| **Санхүүгийн бус өр төлбөрийн дүн** | - | | | 3,077,508.34 | **47,973,156.75** |
| **Өр төлбөрийн дүн** | - | | | **3,077,508.34** | **47,973,156.75** |
| **Эзэмшигчийн өмч** | | | | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 2,500,000,000.00 | | | 2,500,000,000.00 | 2,500,000,000.00 |
| Өмчийн бусад хэсэг | - | | | - | - |
| Хуримтлагдсан ашиг / алдагдал / | 113,490,751.00 | 3,542,108.34 | 88,967,671.58 | 198,916,314.24 | 340,961,441.36 |
| **Эзэмшигчийн өмчийн нийт дүн** | **2,613,490,751.00** | | | **2,698,916,314.24** | **2,840,961,441.36** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **2,613,490,751.00** | | | **2,701,993,822.58** | **2,888,934,598.11** |
| | - | 92,509,779.92 | 92,509,779.92 | - | - |

"ФИСКАЛ АУДИТ" ХХК
FISCAL AUDIT LLC
5384517
УЛААНБААТАР ХОТ

**"ФИСКАЛ АУДИТ" ХХК**

Захирал: Д. Алтантөгс

Аудитор: Н. Болорцэцэг

Шинжээч: Г. Болор

ФИСКАЛ АУДИТ ХХК-Д

**"ГРЭЙТ ЛОРД ББСБ " ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Нарны зам,
Жигүүр Гранд оффис, 7-давхар 702тоот
Утас: 976-72991111, 99110106
И-Мэйл: info@greatlord.mn

2026.03.03 № 12

танай ______________ № ______________ т

*Тайлбар хүргүүлэх тухай*

Манай зээлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй "Эврэст" программд 2024 оны орлого 294,314,034 төгрөгөөр бүртгэгдсэн бол татварын тайланд 220,238,103 төгрөгөөр тайлагнасан бөгөөд 74,075,931 төгрөгийн зөрүү үүссэн байна.

Дээрх зөрүү нь "Эврэст" программ орлогыг аккруэл сууриар бус мөнгөн сууриар тайлагнаж байгаатай холбоотой үүссэн болно. Өөрөөр хэлбэл, программд зөвхөн бодитоор орж ирсэн мөнгөн орлогыг бүртгэж байгаагаас үүссэн байна.

Иймд уг зөрүүг арилгах зорилгоор "Эврэст" программын хөгжүүлэлтийн газарт хандан аккруэл суурийн бүртгэлд нийцүүлэх засвар, тохиргоог хийлгэхээр хандаж, цаашид залруулга хийх болно.

УЛААНБААТАР ХОТ ГРЭЙТ ЛОРД ББСБ ХХК

Хүндэтгэсэн,
ЗАХИРАЛ А.ГАНХҮҮ